

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

“Финанс энд девелопмент оф майнинг ББСБ” ХХК-д  
банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх  
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.8, 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Финанс энд девелопмент оф майнинг ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Финанс энд девелопмент оф майнинг ББСБ” ХХК /Р.Базармаа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ